159

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37 Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.11.15 № 2185
танай 2024.11.06-ны № 32-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Таны 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр "Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар" ирүүлсэн 32 дугаартай асуулгатай танилцлаа.

Төрийн аудитын байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана." гэж заасны дагуу хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийхдээ уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ гүйцэтгэж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл, төлөвлөгөөг төрийн аудитын байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаварт хугацаанд Төрийн хэмнэлтийн хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийхдээ нийцлийн аудитыг хослуулан гүйцэтгэх замаар уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойших сүүлийн хоёр жилд төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар "Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсвийг арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдэж, төсвийн алдагдал буурах, төрийн өмчит байгууллагуудын ашигт ажиллагаа нэмэгдэх үр дүн гарах боломжтой байна", "Хуульд заасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх талаар холбогдох дүрэм, журмыг боловсруулаагүй, байгууллагуудаас татан төвлөрүүлсэн, шилжүүлсэн автомашины бүртгэл, ашиглалт, улсын дугаарын шилжилт хөдөлгөөн, худалдан борлуулалтын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна" гэсэн дүгнэлт өгсөн бөгөөд илэрсэн зөрчилд төсөв захирагч, төрийн өмчит аж ахуйн нэгжид дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

- 2022 онд нийт 61.6 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 20.5 тэрбум төгрөгийн 468 зөвлөмж өгч, 39.4 тэрбум төгрөгийн 908 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1.5 тэрбум төгрөгийн 602 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.2 тэрбум төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.
- 2023 онд нийт 56.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 19.8 тэрбум төгрөгийн зөрчилд 402 зөвлөмж өгч, 36.1 тэрбум төгрөгийн зөрчилд 382 албан шаардлага хүргүүлж, 0.9 тэрбум төгрөгийн 271 төлбөрийн акт тогтоож, 2 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлагыг харьяалах дээд байгууллагад хүргүүллээ.

Z:\Yawsan_Bichig\2024\1115 SUG-1.Docx

0001031597

Монгол Улсын Их Хуралд "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталснаар төсвийн захирагчид төрийн өмч, хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдсэн боловч хуулийн зарим зүйл, заалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх" шаардлагатай талаар толилуулж, Засгийн газарт "Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан зарим арга хэмжээний холбогдох дүрэм журмыг боловсруулж батлуулах, хуулийн хэрэгжилтийг хангасан талаар ил тод тайлагнах, мэдээлэх зохицуулалтыг хийх шаардлагатай" гэсэн зөвлөмжийг өгсөн.

Төрийн аудитын байгууллагаас "Монголбанкаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой авч байгаа арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн", "Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга нар, тээврийн хэрэгсэл, албан тасалгаатай холбоотой хязгаарлалтуудын хэрэгжилт" гэсэн тусгайлсан аудитыг гүйцэтгэсэн болно.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлэх хугацаа хараахан болоогүй байна.

Монгол Улсын Их Хурлын Эрхэм гишүүн Танд Монгол Улсын 2022, 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, "Монголбанкаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой авч байгаа арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн", "Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга нар, тээврийн хэрэгсэл, албан тасалгаатай холбоотой хязгаарлалтуудын хэрэгжилт" сэдэвт аудитын тайланг тус тус хүргүүлж байна.

Хавсралт....хуудастай

Д.ЗАГДЖАВ